



We Save
Your Life
Values and
Lead to
Peaceful
Future



Танилцуулга

“


БИД ТАНЫ АМЬДРАЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ХАМ



ГААЛЖ, АМАР ТАЙВАН ИРЭЭДҮЙД ХӨТӨЛНӨ. ”



www.tavanord.mn



Утас: +976 - 7012-1001

Факс: +976 - 7012-1001

И-мэйл: info@tavanord.mn

Хаяг: ТАВАН ОРД ХХК, "CITY CENTER" 10-р давхар, өрөө 1001,
Алтангэрэлийн гудамж. В-5, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот

Шуудангийн хайрцаг: Central Post-1604 box

“Таван-Орд” ХХК нь 1998 онд үүсгэн байгуулагдсан үндэсний ууган компаниудын нэг юм. Бид байгуулагдсан цагаасаа хойш барилга угсралт, интерьер, экстерьер, холбоо дохиолол, цахилгаан хангамж, галын аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Дээрх хугацаанд галын аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн хамт олныг бүрдүүлж, Улаанбаатар хотод болон орон нутагт нийт 700 гаруй объектод ажил үйлчилгээ хийж гүйцэтгээд байна.



Бид мэргэшсэн дизайны баг, туршлагатай инженер техникийн ажилчид, үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи, 20 гаруй жилийн дадлага туршлага дээр суурилан хэрэглэгчдэд барилга угсралт, засвар үйлчилгээ, интерьер, экстерьер дизайны зураг төсөл, цахилгаан автоматик, холбоо дохиолол, галын аюулгүй байдлын цогц бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэн, салбартаа тэргүүлэгч компани болон ажиллаж байна.



Бид бүхэн 2012 оноос эхлэн “Оюу Толгой” уурхайд “Галын аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт”-ыг үндэсний компаниудаас анхлан олон улсын стандартын дагуу хийж, гүйцэтгэсэн бөгөөд галын аюулгүй байдлын мэргэжлийн цогц үйлчилгээг сүүлийн үеийн технологийн шийдлийг ашиглан, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, улс эх орныхоо хөгжил дэвшил, бүтээн байгуулалтад өөрсдийн мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэл, хөлс хүчээ дайчлан ажиллаж байна.

АЛСЫН ХАРАА

БИД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАСАН,
МЭДЛЭГ ЧАДВАРТ СУУРИЛСАН САЛБАРТАА
ТЭРГҮҮЛЭГЧ КОМПАНИ БОЛНО.

ЭРХЭМ ЗОРИЛГО

БИД ТАНЫ АМЬДРАЛЫН
ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ХАМГААЛЖ, АМАР ТАЙВАН
ИРЭЭДҮЙД ХӨТӨЛНӨ.

ҮНЭТ ЗҮЙЛС

КОМПАНИЙН ОЛОН ЖИЛИЙН МЭДЛЭГ,
ТУРШЛАГА



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ АРГАЧЛАЛ



МЭРГЭЖЛИЙН БАГ ХАМТ ОЛОН



ЧАНАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ



ӨНДӨР ХАРИУЦЛАГА




1998 он

Барилгын засал чимэглэл, тоноглолын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар “Таван-Орд” ХХК үүсгэн байгуулагдав.



2000 он

Цахилгаан, холбоо дохиолол, галын дохиоллын систем, угсралт сууриалтын чиглэлээр үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэв.



2004 он

Гал унтраах хэрэгсэл, галын аюулгүй байдлын бүтээгдэхүүнийг Монгол Улсын зах зээлд худалдаалж эхлэв.



2006 он

Барилга угсралт, барилгын зураг төслийн чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэв.



2017 он

Барилгын цахилгаан, холбоо дохиолол, зураг төслийн чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэв.



2018 он

Ачит-Ихт ХХК -ийн Гидрометаллургийн үйлдвэрт Галын иж бүрэн тоноглол, гал унтраах системийг суурилуулав.



2018 он

Олон улсад нэр хүндтэй гал унтраах системийн SOLBERG брэндийн албан ёсны дистрибьютер болсон.



2018-2019 он

Оюу Толгойн уурхайн “ЧАНДМАНЬ” оффисийн барилгын галын системийн угсралтын ажлыг хийх гүйцэтгэсэн.

Он цагийн хэлхээ



2008 он

Интерьер, экстерьер зураг төсөл, төслийн гүйцэтгэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэв.



2012 он

Оюу толгойн уурхайн галын аюулгүй байдлыг хангаж ажиллах гэрээг үзэглэв.



2014 он

Олон улсад нэр хүндтэй Тусо брендийн албан ёсны төлөөлөгч болов.



2016 он

Оюу толгойн Ханбумбат нисэх онгоцны буудлын гал унтраах аврах ангийн бие бүрэлдэхүүнийг томилох гэрээг үзэглэв.



2019 он

Оюу Толгой уурхай дахь Химийн агуулахын галын дохиолол, унтраах системийн угсралтыг хийж гүйцэтгэх гэрээг үзэглэв.



2019 он

Олон Улсын Чанарын Стандартын ISO-9001 гэрчилгээг Канад Улсад төвтэй PESB байгууллагаас батламжлав.



2019-2020 он

Шинэ нисэх онгоцны буудлын агаарын хөлгийн "АНГАР"-ын барилгын галын хөөсөн, усан, аэрозоль системийн угсралт суурилуулалтыг хариуцан гүйцэтгэв.



2020 он

Улаанбаатар хотын шинэ онгоцны буудлын бизнес ангиллын танхимын дотоод тохижуулалт, интерьер, галын дохиоллын ажлыг хийж гүйцэтгэв.

Бидний давуу тал



Цахилгаан, холбоо дохиолол болон галын иж бүрэн системийн угсралт суурилуулалтыг хийсэн хамгийн олон жилийн туршлагатай.



Өргөн сонголттой орчин үеийн дэвшилтэд технологийг цаг тухай бүрт манлайлан нэвтрүүлсэн.



Орчин үеийн шийдэлтэй галын дохиолол болон гал унтраах системийг суурилуулдаг.



Чадварлаг хамт олон, олон жил ажилласан туршлагатай ажилтан, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлдэг.



Хямдрал урамшуулал, тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн зааварчилгааг цаг алдалгүй өгдөг.



Угсралт суурилуулалтандаа урт хугацааны чанарын баталгаа өгдөг.



Бид компанидаа Канад улсад төвтэй олон улсын PECB MS байгууллагаас олон улсын чанарын удирдлагын тогтолцоо буюу ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн.

Бидний үйл ажиллагааны чиглэлүүд

“Таван орд” ХХК нь дараах чиглэлүүдэд үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнд:



ГАЛЫН ДОХИОЛОЛ
УГСРАЛТ
СУУРИЛУУЛАЛТ



ГАЛЫН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН
ҮНЭЛГЭЭ



ОРОН СУУЦ,
БАЙГУУЛАМЖИЙН
УХААЛАГ СИСТЕМ
СУУРИЛУУЛАЛТ



ХОЛБОО ДОХИОЛОЛ
ЦАХИЛГААН
ХАНГАМЖ



ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ
СУУРИЛУУЛАЛТ



БАРИЛГА УГСРАЛТ



ИНТЕРЬЕР, ЭКСТЕРЬЕР
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ,
СУРГАЛТ



“ БИД ТАНЫ АМЬДРАЛЫН
ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ХАМГААЛЖ,
АМАР ТАЙВАН ИРЭЭДҮЙД
ХӨТӨЛНӨ. ”

БАРИЛГА
УГСРАЛТ



ИНТЕРЬЕР,
ЭКСТЕРЬЕР



ГАЛЫН ДОХИОЛОЛ
БОЛОН УНТРААХ
СИСТЕМИЙН
УГСРАЛТ,
СУУРИЛУУЛАЛТ



ХОЛБОО ДОХИОЛОЛ,
ЦАХИЛГААН ХАНГАМЖ,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
СУУРИЛУУЛАЛТ



ОРОН СУУЦ, ХАУС БОЛОН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
УХААЛАГ СИСТЕМИЙН
СУУРИЛУУЛАЛТ





БАРИЛГА УГСРАЛТ

100+

Барилгын
мэргэшсэн
ажилчид

50+

Орчим
барилгын засал
болон угсралтын
төсөл

100+

Хүнийг ажлын
байраар
хангасан

Таван орд ХХК нь Монгол Улсын хөгжил дэвшлийн нэг хэсэг болох барилга, хот байгуулалтын салбарыг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулан ажилласаар ирсэн билээ.

Өнөөдрийн байдлаар манай компани нь 70 гаруй үндсэн ажилчин, 100 гаруй гэрээт ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 10 гаруй өндөр мэргэжлийн инженер техникийн ажилтан, 100 гаруй барилгын мэргэшсэн ажилчид бүхий ажиллах хүчний бааз суурь дээр түшиглэн үйл ажиллагаа явуулж байна.

Манай компани жилд 50 орчим барилгын засал болон угсралтын төсөл дээр ажиллаж, бүтээн байгуулалтыг явуулж 100 гаруй хүнийг ажлын байраар хангаж, тэдний хэвийн ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлсэн ба цалинг амжиргааны доод түвшинээс 3-6 дахин өндөр үзүүлэлтэнд хүргэсэн юм.

70+


Үндсэн
ажилчин

100+

Гэрээт
ажиллагсадтай

10+

Өндөр мэргэжлийн
инженер
техникийн
ажилтан



ИНТЕРЬЕР, ЭКСТЕРЬЕР

Интерьер экстерьерийн салбар Таван Орд ХХК-д байгуулагдсанаас хойших хугацаанд удирдлага, бүтэц бүрэлдэхүүн, аж ахуй, санхүү, материаллаг баазын хувьд бүрэн бэхжсэн салбар юм.

Мэргэшсэн дизайны баг, туршлагатай инженер техникийн ажилчид, үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи, 10 гаруй жилийн дадлага туршлага дээр суурилан интерьер, экстерьер дизайны зураг төсөл, тавилга үйлдвэрлэл, барилгын

засвар үйлчилгээний чиглэлээр салбартаа тэргүүлэгч компани болон өргөжин хөгжөөд байгаагаас гадна Монгол улсын тэргүүлэгч компаниудтай хамтын ажиллагаа явуулж байна.

Манай байгууллага нь “Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам”-аас олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу Барилга угсралт, интерьер, экстерьерийн ажлаар 150 гаруй ажил үйлчилгээ хийсэн туршлагатай хамт олон юм.

Барилга угсралт,
интерьер,
экстерьерийн ажлаар
150
гаруй объект

Өнөөг хүртэл
500
гаруй зураг төсөл,
засвар үйлчилгээ
гүйцэтгэсэн

Таван Орд ХХК өнөөг хүртэл 500 гаруй зураг төсөл, засвар үйлчилгээ гүйцэтгэснээс: “Скайтел” компанийн нийслэл болон орон нутаг дахь бүх салбаруудын зураг төсөл гүйцэтгэл, “Мобиком” корпорацийн нийслэл болон орон нутаг дахь салбарууд зэрэг 160 гаруй объектын зураг төсөл гүйцэтгэлийг хийсэн. “Улаанбаатар Хотын Банк” “Голомт Банк” “Худалдаа Хөгжлийн Банк” “Кредит Банк” зэрэг банкуудын интерьерийн зураг төсөл, засварын ажлыг гүйцэтгэсэн.



Schneider LLC-ийн
захиалгаар
гүйцэтгэсэн ажил



Капитрон банкны
захиалгаар хийж
гүйцэтгэсэн ажил



Бороо гоулд ХХК-ийн
захиалгаар
гүйцэтгэсэн ажил



МЭРГЭШСЭН
ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН
АЖИЛЧДЫН
БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ

ГАЛЫН ДОХИОЛОЛ,
УГСРАЛТ
СУУРИЛУУЛАЛТЫГ
ЧАНАРЫН ӨНДӨР
ТҮВШИНД ХИЙЖ
БАЙНА.



ГАЛЫН ДОХИОЛОЛ БОЛОН УНТРААХ СИСТЕМИЙН УГСРАЛТ, СУУРИЛУУЛАЛТ

Галын дохиоллын систем нь гал түймрээс үүсэх хүчин зүйл буюу утаа, дулаан, агаар дахь хийн найрлага, нягтарлын өөрчлөлтөөр гал гарах үед мэдэрч, дуут болон гэрлэн дохиоллын тусламжтайгаар зарлан мэдээлэх, улмаар агаар сэлгэлтийн систем, зарим үйлдвэр технологийн үйл ажиллагааг зогсоох, гал унтраах системийг идэвхжүүлэх зэргээр гал түймрээс үүсэж болох хохирол, сөрөг үр дагаврыг хамгийн бага түвшинд нь таслан зогсооход чиглэгдсэн илрүүлэх, дамжуулах, хүлээн авах, хянах, зохицуулах зарлан мэдээлэх үйлдэл бүхий цогц шийдэл бүхий систем юм.

Бид албан байгууллага, орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилгуудад галын дохиоллын системийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, системийн ашиглалт, засвар үйлчилгээг нь хариуцан ажиллаж байна. Манай компани нь дэлхийд тэргүүлэгч TYCO ХХК болон Швейцарь улсын SECURITON ХХК-ны албан ёсны төлөөлөгчийн эрхийн дагуу галын дохиолол болон гал унтраах автомат системийн тоног төхөөрөмжүүдийн угсралт суурилуулалтыг хийж байна.

Бид үйлчилгээндээ дэлхийн шилдэг дараах брэндүүдийн бүтээгдэхүүнүүдийг хэрэглэж байна.



ОХУ-ын Магистраль группийн галын дохиоллын систем



АНУ-ын TYCO ХХК-ийн SIMPLEX брэндийн галын дохиоллын систем



Швейцарь улсын SECURITON брэндийн галын дохиоллын систем



АНУ-ын TYCO ХХК-ийн галын усан хангамжийн систем



АНУ-ын TYCO ХХК-ийн ANSUL брэндийн гал унтраах систем



Европийн CE стандартад бүрэн нийцсэн GST брэндийн галын дохиоллын систем



Австралийн гал унтраах хөөсөн систем, байгальд ээлтэй хөөс нийлүүлдэг Solberg компанийн албан ёсны борлуулагч



ХОЛБОО ДОХИОЛОЛ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАЛТ

Таван Орд ХХК таны хүссэн зураг, төсөв, шийдлийн дагуу барилгын ил болон далд монтаж угсралтыг стандартын дагуу хурдан шуурхай хийж гүйцэтгэх бөгөөд та өөрийн барилга байгууламжийн цахилгаан хангамжийн шийдлийг гаргахдаа манай мэргэжлийн инженер, техникийн ажилчдаас тусламж зөвлөгөө авах боломжтой.

Мөн дотор болон гадна бүх төрлийн гэрэлтүүлгийг таны хүссэн интерьер дизайны шийдэлд тохируулж, хэрэглээний хүчин чадалтай нь уялдуулан иж бүрэн угсарч суурилуулна. Хоёр талаас унтраалгатай гэрэлтүүлэг, хөдөлгөөн мэдрэгчтэй, ослын үеийн болон оффис, орон сууц, авто зогсоол зэрэг бүхий л барилга байгууламжийн гэрэлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэдэг. Бид холбоо, дохиолол, дотор гадна цахилгааны угсралтын чиглэлээр нийслэл болон хөдөө орон нутагт 700 гаруй объектод угсралт, суурилуулалт хийсэн туршлагатай.

Эрчим хүч зохицуулалтын салбарт дэлхийд тэргүүлэгч Шнайдэр, ABB, IEK, CHINT фермийн тоног төхөөрөмжүүдээр эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэр, дата төв, сүлжээ, барилга угсралт, орон сууцны зах зээлд зориулан эрчим хүчийг аюулгүй, найдвартай, хурдан шуурхай, үр бүтээмжтэй болгох цогц шийдэл болсон самбар шитийг Монгол улсын барилгын стандарт норм, дүрмийн дагуу угсарч зах зээлд нийлүүлж байна.





АВТОМАТ
УДИРДЛАГЫН
СИСТЕМ НЬ ТАНЫ
АЖЛЫГ ХӨНГӨВЧИЛЖ,
ЦАГИЙГ ХЭМНЭХ
ДАВУУ ТАЛТАЙ



ОРОН СУУЦ, ХАУС БОЛОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН УХААЛАГ СИСТЕМИЙН СУУРИЛУУЛАЛТ

Гэрэл, цахилгаан



Халаалт дулаан



Сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох орон сууцны болон бусад төрөл бүрийн барилга байгууламжийн гэрэл, цахилгаан, халаалт дулаан, болон камерын систем дохиоллыг ухаалаг төхөөрөмжийн тусламжтайгаар алсаас удирдах хянах боломжийг бүрдүүлсэн цогц системийг манай байгууллага Монгол Улсад оруулж ирэн суурилуулж байна.

Энэхүү системийг иргэн, байгууллага өөрсдийн орон сууц болон барилга байгууламжид суурилуулснаар таны хамгийн үнэт зүйл болох үл хөдлөх хөрөнгийг элдэв эрсдэлээс хамгаалах бөгөөд ухаалаг системийг ашиглан эрчим хүч, дулааны хэмнэлтийг гаргах боломжтой ба байгууламжийн хяналтыг алсын зайнаас цаг алдалгүй хийх боломжтой юм.

Камер



Автомат удирдлагын систем



Харилцагч байгууллагууд





Утас: +976 - 7012-1001
Факс: +976 - 7012-1001
И-мэйл: info@tavanord.mn

Хаяг:
ТАВАН ОРД ХХК
“CITY CENTER” 10-р давхар, өрөө 1001,
Алтангэрэлийн гудамж. В-5,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Шуудангийн хайрцаг:
Central Post-1604 box